

Бодлогын ангилал

Топкодер өөрийн бодлогуудаа ангилахаар шийджээ.

Ингээд топкодерыг хөгжүүлэгчид бодлогын түвшин нь зөвхөн бодлогын өгүүлбэрт байгаа үгүүдийн дундаж уртаас хамаарна гэж үзсэн.

Хэрэв Үгийн Дундаж Урт 3 болон түүнээс бага тоо байвал уг бодлого 250 онооны бодлого байна.

Хэрэв Үгийн Дундаж Урт 4 эсвэл 5-тай тэнцүү байвал уг бодлого 500 онооны бодлого байна.

Хэрэв Үгийн Дундаж Урт 6 болон түүнээс дээш утгатай бол уг бодлого 1000 онооны бодлого байна.

Тодорхойлолт:

Токен - хоёр талаасаа хоосон зай эсвэл өгүүлбэрийн эхлэл, төгсгөлөөр хязгаарлагдсан тэмдэгтүүдийн олонлог.

Үг - зөвхөн үсэг агуулсан (a-z, A-Z), эцэстээ ганц цэгтэй байж болох Токен. Үг ядаж нэг үсэгтэй байх ёстой.

Үгийн урт - Үгэнд орсон үсэгнүүдийн тоо (цэг бол үсэг биш юм).

Дараах токenuуд нь үг юм:

"ab", "ab."

Харин эдгээр нь үг биш:

"ab.", "a.b", ".ab", "a.b.", "a2b.", "."

Үгийн Дундаж Урт - бодлогын өгүүлбэрт байгаа Үгсийн Уртуудын нийлбэрийг Үгсийн нийт тоонд хуваасан харьцаа.

Энэ хуваах үйлдэл нь бүхлээр хуваах үйлдэл юм.

Хэрэв Үгсийн нийт тоо нь тэгтэй тэнцүү бол Үгийн Дундаж Урт тэгтэй тэнцүү байна.

Бодлогын өгүүлбэр өгөгдсөн бол уг бодлогыг хэдэн онооны бодлого болохыг ол.

Өгүүлбэрийг зүүнээс баруун тийш боловсруулна.

Input

Бодлогын өгүүлбэр нь 50 хүртлэх тэмдэгтийн урттай, үсэг, тоо, зай, цэг агуулсан тэмдэгт мөр байна.

Output

Бодлогын оноог хэвлэнэ

Example

Input:

Implement a class H5 which contains some method.

Output:

500